

Архангай аймаг дахь
төрийн аудитын газар



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

| 2021



АГУУЛГА

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН	2
УДИРДЛАГА, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	7
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	8
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ	15
ӨӨРИЙН САНААЧИЛГААР ХИЙСЭН АУДИТ	17
ДОТООД АЖИЛ	18
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	22
ДҮГНЭЛТ, ЦААШДЫН ЗОРИЛТ	22



ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Монгол Улсын ерөнхий аудиторын 2021 оны А/09 тушаалаар Төрийн аудитын байгууллагын 2021 оны зорилтыг **“Аудитыг цахимжуулж, нэгтгэн удирдах тогтолцоог бүрдүүлэн, төлөвшүүлэх”** гэж тодорхойлон баталсан.

Энэ зорилтын хүрээнд батлагдсан *“Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”*-нд үндэслэн аймаг дахь Төрийн аудитын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч болон Тамгын даргаар батлуулж, гүйцэтгэлийг тайлагнаж ирлээ.

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлангаа танилцуулж байна.

Архангай аймаг дахь Төрийн аудитын газар нь МУЕА ын 2021 оны 3 сарын 4-ны өдрийн А/27 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн Архангай аймаг дахь ТАГ ын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 бүлэг 9 зорилтын хүрээнд 41 арга хэмжээг төлөвлөснөөс эхний хагас жилийн байдлаар 11 арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангуулан, улирал дамнан хэрэгжих 20 арга хэмжээний хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна. Мөн жилийн турш болон улирал дамнан хэрэгжих арга хэмжээнүүдийн тухайн хугацаанд хамаарах үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлээд байна.

Зорилт-1: Төрийн аудитын бодлого төлөвлөлт, стандарт арга зүй хүрээнд ТАГ-с дэвшүүлсэн 1 зорилтын хэрэгжилт 4-р улиралд тайлагнагдахаар байна.

Зорилт-2: Төрийн аудитын үйл ажиллагааны хүрээнд төлөвлөсөн ажлын хэрэгжилт 100% байна. Энэ зорилтын хүрээнд аудиттай холбоотой 7-н арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангууллаа.

- Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан санхүүгийн тайлангийн 4-н аудит, Нэгдсэн төлөвлөгөөт "УТХО-ын 2020 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" д хийсэн гүйцэтгэлийн аудит, ИТХ-ын санаачилгаар "ОНХСангийн 2020 оны хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэх, өөрийн санаачилгат "Орон нутгийн төсвийн 2020 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" нд хийсэн гүйцэтгэлийн аудитыг төлөвлөсөн хугацаанд бүрэн хийж, тайланг үйлчлүүлэгч байгууллагад хүргүүлэн ажиллалаа.
- Төлөвлөгөөний дагуу ТАГ-ын 2022 онд гүйцэтгэх аудитын сэдвийн саналыг МУЕА-ын 2017 оны 131-р тушаалаар батлагдсан “Төрөлжсөн болон аймаг нийслэл дэх төрийн аудитын газрын гүйцэтгэх сэдвийг сонгох, төлөвлөх бүртгэх, гүйцэтгэх тайлагнах журам” болон Төрийн аудитын тухай хуулийн 11-р зүйлийн дагуу саналыг боловсруулан ХБТГ-т хүргүүллээ.



- Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 2022 онд хийх Санхүүгийн тайлангийн аудитын хуваарийг тайлангийн жилд хийсэн санхүүгийн аудитын мэдээлэлд тулгуурлан, дараа жилд хамрагдах үйлчлүүлэгчдийн тоо болон аудит хийх хэлбэрийг судлан, хуваарийн саналыг холбогдох маягтаар гарган Аудитын Нэгдүгээр газарт хүргүүлээд байна.
- Санхүүгийн тайлангийн аудитыг хуулийн цаглаварт хугацаанд хүн хүчний нөөцөд тулгуурлан чанартай гүйцэтгэх үүднээс аудитад Төрийн аудитын тухай хуулийн дагуу гэрээний үндсэн дээр аудитын хуулийн этгээд болон гэрээт ажилтныг оролцуулан ажиллалаа. Төлөвлөгөөний дагуу аудитын хуулийн этгээдийн болон гэрээт ажилтнуудын гүйцэтгэсэн 92 санхүүгийн тайлангийн аудитад чанарын хяналтыг үе шат бүрд хэрэгжүүлэн, аудитын тайланг үйлчлүүлэгч байгууллагад хүргүүлэн ажиллалаа.
- Аудитын хуулийн этгээдийн гүйцэтгэсэн 30-н төсөв захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитын ажлын гүйцэтгэлийг МУЕА ын А/81-р тушаалын дагуу аудитын үе шат бүрд аудитор, ахлах аудитор, менежер Тэргүүлэх аудиторуд ажлын баримтад тулгуурлан үнэлгээ өгч, хуулийн этгээдүүдэд танилцуулан дүгнээд байна. Үнэлгээний дунджаар дээрх 2 ХАК нь “Хангалттай” үнэлгээ авсан бөгөөд 2021-2022 оны санхүүгийн тайлангийн аудитад гэрээг дахин үргэлжлүүлэн ажиллуулах тухай мэдэгдээд байна. Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хуулийн этгээдүүд нь Ковид -19 цар тахлын хөл хорионы улмаас орон нутагт бүрэн хэмжээгээр ирж ажиллаагүй бөгөөд гүйцэтгэсэн ажлыг тухай бүр СТАУС программаар хянаж санал зөвлөгөө өгч хамтарч ажиллаж байлаа. Хуулийн этгээдүүдийн ажлын гүйцэтгэл, гэрээ дүгнэсэн акт, үнэлгээний нэгтгэлийг Аудитын Нэгдүгээр газарт хүргүүллээ.
- Харин Үүнд: Төрийн аудитын байгууллагын харилцаа хамтын ажиллагаа, хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хүрээнд эхний хагас жилд хийгдсэн аудитын нээлт болон аудитын дүнгийн талаар цахим сайтад байршуулсан ба 2020 оны байгууллагын үйл ажиллагааны тайлан, ОНХСангийн тайлангуудыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажиллалаа. Төрийн аудитын үйл ажиллагааны хүрээнд нэгдсэн удирдамжтай хийгдэх 2 аудитын төлөвлөлтийн өмнөх шатны ажил хийгдсэн, төлөвлөлтийн шатны ажлыг эхлүүлэх ажил хүлээгдэж байна. 3. Хүний нөөцийн бодлого стратегийн хүрээнд тусгагдсан 5 арга хэмжээ, Дэмжих үйлчилгээний хүрээнд төлөвлөсөн 12-н арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Зорилтын хүрээнд санхүү, гүйцэтгэл, нийцлийн нийт 7-н аудит, аудиттай холбоотой 4-н ажлууд нийт 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хагас жилд санхүүгийн 4, гүйцэтгэлийн 3, нийцлийн 2 аудит, аудиттай холбоотой 7 ажил, нийт 16 ажлыг төлөвлөгөөт хугацаанд гүйцэтгэн, 5 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөсөн хугацаа болоогүй байна.



Зорилт-3: Харилцаа хамтын ажиллагаа, хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ нь бүтэн жилийн турш хэрэгжихээр төлөвлөгдсөн бөгөөд эхний хагас жилд дараах ажлыг хийгээд байна.

- Төрийн аудитын байгууллагын цахим сайт шинэчлэгдсэнтэй холбоотой Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 онд хийж гүйцэтгэсэн санхүүгийн аудитын 2670 хуудас бүхий 162 тайлан, Гүйцэтгэлийн аудитын 231 хуудас бүхий 10-н тайлан, Нийцлийн аудитын 74 хуудас бүхий 4-н нийт 176 тайланг цахим сайтад байршуулаад байна. 2021 оны эхний хагас жилд “Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянан баталгаажуулж нийтэд мэдээлэх”, “2020 оны УТХО-ын үр дүн, үр нөлөө”, “2020 оны ОНТХО-ын үр дүн, үр нөлөө”, “ОНХС-ийн 2020 оны хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэх” сэдэвт 4 аудитын тайлан, Санхүүгийн тайлангийн аудитын ТШЗ-ийн 129, ТТЗ-ийн 19, ТБОНӨГ-ын 4, аймгийн ТЕЗ-ийн 1, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн 1 тайлан, нийт 158 тайланг цахим сайтад байршуулсан байна. Мөн үйл ажиллагаатай холбоотой 13 мэдээллийг сайтад байршуулаад байна. Байгууллагын фейсбүүк хаягаар үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл - 7, авлигын эсрэг соён гэгээрүүлэх портер, шторк - 3, ковид цар тахлаас урьдчилан сэргийлэх нөлөөллийн портер - 2 ыг тус тус байршуулж олон нийтэд хүргэж ажиллалаа.

Зорилт-4: Хүний нөөцийн бодлого, сургалт сурталчилгааны хүрээнд 5-н арга хэмжээ нь жилийн турш хэрэгжих бөгөөд эхний хагас жилд дараах ажлуудыг хийлээ.

- ТАГ-ын ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээг сахих, ашиг сонирхлын зөрчил гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх, чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан эхний хагас жилд аудиторуудын гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн 153, гүйцэтгэлийн 2, нийцлийн 1 нийт 156 аудит бүрд төлөвлөлтийн үе шатанд ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийн баталгаа гарган ажиллалаа. Мөн Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторовын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Байгалмаа МУЕА-ын 2021 оны А/52 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг 2021.05.11-ний өдөр бүх ажилтнуудад танилцуулж, цаашид ёс зүйн хэм хэмжээ, хуулиар тодорхойлсон үүргийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, албаны үүргийг зохих ёсоор гүйцэтгэх, мэргэжлийн зарчимч байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх талаарх сургалт зохион байгууллаа. Түүнчлэн ҮАГ-ын ХБТГ-аас 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан “ТАБ-ЫН ШИНЭЭР БАТЛАГДСАН ДҮРЭМ, ЖУРМУУДЫГ ТАНИЛЦУУЛАХ ЦУВРАЛ СУРГАЛТ-I”-ын хүрээнд Ёс зүйн дүрмийн сургалтад бүх ажилтнууд дахин бүрэн хамрагдсан бөгөөд ёс зүйн дүрэмд заасан хэм хэмжээг сахиж, хуулиар тодорхойлсон албаны үүргийг шударга, алдаа, зөрчилгүйгээр гүйцэтгэхэд ажилтан бүр анхаарч хичээн ажиллаж байна.



- Байгууллагын албан хаагчид 2020 оны ХАСХОМ-ийг шинэчлэн гаргаж ХОМ-ээ хуулийн хугацаанд буюу 2021.02.15-ны өдрөөс өмнө цахим системд оруулж баталгаажуулсан. Ажилтнуудын баталгаажсан ХОМ-ийг байгууллагын эрх бүхий албан тушаалтан цаасаар авч, архивлаад байна. Архангай аймаг дахь төрийн аудитын газрын 2021 оны авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Тэргүүлэх аудиторын 2021.05.11-ний өдрийн А/18 дугаар тушаалаар батлан, төлөвлөгөөний дагуу 2021 оны эхний хагас жилд ажлын фэйсбүүк хуудсаар Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 6 дугаар зүйлийн 6.1.6-д заасан үүргийн хүрээнд Авлигатай тэмцэх газраас гаргасан шторкуудыг цувралаар хүргэж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. МУЕА-ын 2020 оны А/93 дугаар тушаалаар батлагдсан "Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх журам"-ыг ажилтнуудад танилцуулах сургалтыг зохион байгуулж, Төрийн аудитын байгууллагын ажилтны тангаргийг бүх ажилтнуудад ил тод харагдаж байхаар хэвлүүлэн албан өрөөнд байршуулаад байна. Авлигын эсрэг төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг ЗУ-ын газар болон МУЕА ын орлогчид хүргүүллээ.

Зорилт-5: Төрийн аудитын байгууллагын дотоод засаглал, үйл ажиллагааг дэмжих үйлчилгээний хүрээнд төлөвлөгдсөн 13-н арга хэмжээг жилийн турш хэрэгжүүлэхээр төлөвлөснийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэн эхлээд байна.

Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор холбогдох төлөвлөгөөнүүдийг Тэргүүлэх аудиторын тушаалаар батлан мөрдөн ажиллаж байна. Тухайлбал: Дотоод ажлын төлөвлөгөө, мэргэжлийн тасралтгүй сургалтын төлөвлөгөө, Авилгаас урьдчилан сэргийлэх 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Тэргүүлэх аудиторын 2021 оны А/14, А/18 тушаалаар тус тус баталлаа.

Төрийн аудитын газрын 2021 оны эхний хагас жилийн үндсэн үйл ажиллагаа, түүний үр дүнг товч тоон үзүүлэлтээр танилцуулбал: /2021 оны 06 сарын 23-ны өдрөөр тасалбар болгов /

- *Тайлангийн хугацаанд ТАГ нь санхүүгийн аудит 154, гүйцэтгэлийн -2, нийцлийн -2, нийт 158 аудит хийж аудитад нийт 291 байгууллага, хуулийн этгээдийг хамруулсан байна.*



- Аудитаар **58649.1** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж үүнээс 9571.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий 62 алдаа зөрчлийг аудитын явцад залруулж бусад зөрчлийг залруулахаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгсөн байна.



- Төрийн аудитын газар 2021 оны эхний хагас жилд **20327.3** сая төгрөгийн үр өгөөжийг аудитад хамрагдсан байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн нь төсвийн “Нэг” төгрөгийн санхүүжилт тутамд **82** төгрөг 43 мөнгөний үр өгөөжийг бий болгосон байна.

Төлбөрийн акт: Тайлант хугацаанд **99.3** сая төгрөгийн 51 төлбөрийн акт тогтоосон ба өмнөх оны болон тайлангийн хугацааны нийт **61.2** сая төгрөгийн 39 төлбөрийн актыг барагдууллаа. Тайлант хугацааны төлбөрийн актын хэрэгжилт 61.7% байна. Хэрэгжих хугацаа болоогүй 30.8 сая төгрөгийн 8, хугацаа хэтэрсэн 7.3 сая төгрөгийн 4 төлбөрийн актын үлдэгдэлтэй байна.



Албан шаардлага: Тайлангийн хугацаанд **17869.1** сая төгрөгийн зөрчил арилгуулах 162 албан шаардлагыг шалгадагч байгууллагад хүргүүлсэн ба өмнөх оны болон тайлангийн хугацааны нийт **15117.8** сая төгрөгийн 157-н албан шаардлагын биелэлтийг хангуулжээ. Тайлант онд өгсөн **6944.9** сая төгрөгийн 34-н албан шаардлагын хэрэгжих хугацаа болоогүй үлдэгдэлтэй буюу албан шаардлагын хэрэгжилт 84.6% байна.



Зөвлөмж: Төрийн аудитын газраас тайлангийн хугацаанд хийсэн аудитаас нийт **31109.6** сая төгрөгийн 362 зөвлөмж хүргүүлж өмнөх оны болон тайлант хугацааны нийт **9270.0** сая төгрөгийн 264 зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулаад байна. Хэрэгжих хугацаа болоогүй **21839.7** сая төгрөгийн дүнтэй 98 зөвлөмжийн үлдэгдэлтэй буюу зөвлөмжийн хэрэгжилт 70.2% байна. Үүний учир нь тайлант онд хийгдсэн аудитаас

өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийг оны сүүлийн хагаст үнэлэхээр тооцсонтой холбоотой байна.

Нийт зөвлөмжийн 41.3 хувийг санхүүгийн, 47.1 хувийг гүйцэтгэлийн, 11.6 хувийг нийцлийн аудитын дүнд тус тус үндэслэн хүргүүлснээс ангиллыг харвал дотоод хяналттай холбоотой зөрчилд 46.6%, хууль тогтоомжийн хэрэгжилт 26.5%, НББ тайлагналтай холбоотой 24.1 хувь байгаа нь зөвлөмжийн дийлэнх хувийг эзэлж байна.



Санхүүгийн тайлангийн аудитаар тайлангийн хугацаанд зөрчил гаргасан 8-н албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлснээс биелэлт 75% тай байна.

Тайлант хугацаанд хийсэн аудитаас хууль хяналтын байгууллагад шинээр шилжүүлсэн асуудал байхгүй. Харин өмнөх онд шилжүүлсэн 149.9 сая төгрөгийн 4 асуудал хянагдаж байна.



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Архангай аймаг дахь Төрийн аудитын газар нь тайлангийн хугацаанд Монгол улсын Ерөнхий аудиторовын баталсан “Аймаг нийслэл дэх төрийн аудитын газрын бүтэц батлах тухай тушаал”-ын дагуу 12 орон тоотой ажиллахаас 11 орон тоо, нягтлан бодогч бичиг хэргийн ажилтан гэрэгээр ажиллаж байна.

БАТЛАГДСАН ОРОН ТОО - 12

ГҮЙЦЭТГЭЛ -11

Нийт ажиллагсдын 76.9% нь эдийн засагч, нягтлан бодогчийн мэргэжилтэйгээс 50% нь Мэргэшсэн нягтлан бодогчид байна.



Тайлангийн хугацаанд хамт олны хурал 1, Удирдлагын зөвлөлийн хурал 1 удаа хуралдаж, холбогдох шийдвэрүүдийг гаргалаа. Аудиторуудын ажлын гүйцэтгэл, үр дүнг журмын дагуу улирал, хагас жилээр үнэллээ.

2021 оны эхний хагас жилд хийсэн санхүүгийн аудитын 154, гүйцэтгэлийн 2, нийцлийн 2 нийт 158 тайланг шалгагдагч байгууллага болон холбоотой талуудад хүргүүлсэн байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ



Архангай аймаг дахь Төрийн аудитын газар нь 2021 гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглаврын хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/ 64 дүгээр тушаал, ТАГ-ын дарга тэргүүлэх аудиторын 2020 оны 07 дугаар сарын 09-ны А/17 тоот тушаалын дагуу 2020 оны санхүүгийн тайлангийн аудитыг хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар бүх шатны төсөвт байгууллагын санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, НББОУС болон үндэсний стандартад нийцүүлэн үнэн зөв тайлагнасан эсэх талаар санал дүгнэлт гарган баталгаажууллаа.

Аудитад ТАГ-ын үндсэн 9 аудитор, 3 гэрээт ажилтан, 2 ХАК оролцон, аудитын менежер болон тэргүүлэх аудитор аудитыг хянан удирдаж, үе шатны хяналтын хэрэгжүүлэн 74 өдөр зарцуулж, 3383 илүү цаг суун, нэг аудитор дунджаар 11 төсөв захирагчийн санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргаж ажилласан байна.




Санхүүгийн тайлангийн аудитад улс, орон нутгийн төсөвт байгууллага, орон нутгийн болон засгийн газрын тусгай сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, аймаг, сумдын төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт 251 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийснээс 153 байгууллагын санхүүгийн тайланд санал дүгнэлтийг гаргаж, 18 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлэн, 80 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгалаа.

СТА-Д ХАМРАГДСАН БАЙДАЛ






Аудитын санал дүгнэлтийн 137 буюу 89.5% “Зөрчилгүй”, 14 буюу 9.2% нь Хязгаарлалттай, 2 буюу 1.3 % нь татгалзсан дүгнэлт өгсөн нь өмнөх онтой харьцуулахад хязгаарлалттай санал дүгнэлтийн тоо 1-ээр, татгалзсан санал дүгнэлтийн тоо 2-оор, зөрчилгүй санал дүгнэлтийн тоо 5-аар тус тус буурсан байна. Харин түүвэрт хамруулах байгууллагын тоо өмнөх оноос 8, итгэл үзүүлэх 1-ээр тус тус нэмэгджээ.



Төрийн аудитын газар санхүүгийн тайлангийн аудитаар нийт **34133.3** сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 28.0 хувь буюу **9,571.0** сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэн, 37.7 хувь буюу **12,857.4** сая төгрөгийн зөрчилд **316** зөвлөмж, 34.0 хувь буюу **11,606.6** сая төгрөгийн зөрчилд зөрчлийн арилгуулах, таслан зогсоох, хууль журмын хэрэгжилтийг хангаж ажиллах 151 албан шаардлага, 0.3 хувь буюу **98.2** сая төгрөгийн зөрчилд 50 төлбөрийн акт тогтоолоо. Нийт илрүүлсэн алдаа зөрчлийн дүн өмнөх оноос 2.8 дахин, залруулсан алдаа 2 дахин тус тус өссөн байна.




Аудитаар залруулагдаагүй **24562.3** сая төгрөгийн алдаа зөрчлөөс 50 зөрчилд 98.2 сая төгрөгийн төлбөрийн акт, 151 зөрчилд 11606.6 сая төгрөгийн албан шаардлага өгч, 12857.4 сая төгрөгийн зөрчилд 316 зөвлөмж тус тус хүргүүллээ. Аудитаар алдаа зөрчил гаргасан 8 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж 75%ийн хэрэгжилтийг хангууллаа.


Нийт алдаа зөрчлийн 53.0 хувийг НББ тайлагналтай холбоотой, 43.0 хувийг хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, 3.0 хувийг арвилан хэмнэлт, үр ашиг үр нөлөөтэй холбоотой, 0.6 хувийг худалдан авалттай холбоотой, 0.4 хувийг төсвийн төлөвлөлт, орлого бүрдүүлэлттэй холбоотой, 0.3 хувийг зориулалт бус зарцуулсан, 0.2 хувийг хувь дотоод хяналт хариуцлагатай холбоотой бусад зөрчлүүд тус тус эзэлж байна.

Төлбөрийн актын хэрэгжилтийн талаар:

Тайлант хугацаанд **98.2** сая төгрөгийн **50** төлбөрийн актыг тогтоосноос эхний хагас жилийн байдлаар **60.1** сая төгрөгийн **38** төлбөрийн актын хэрэгжилтийг хангуулан ажилласан бөгөөд 23.7 сая төгрөгийн 5 төлбөрийн акт ковид цар тахал болон бусад нөхцөл байдлаас шалтгаалан хугацаа хэтэрч, 14.4 сая төгрөгийн актын 7 төлбөрийн актын хэрэгжих хугацаа болоогүй байна.



Албан шаардлагын хэрэгжилтийн талаар: нийт Тайлант хугацаанд **11,606.8** сая төгрөгийн зөрчлийг арилгуулах, таслан зогсоох **151** албан шаардлага хүргүүлснээс **10,995.8** сая төгрөгийн **127** албан шаардлагын биелэлтийг хангуулж, эхний хагас жилийн байдлаар биелэлт **94.7** хувьтай байгаа бөгөөд **610.5** сая төгрөгийн **24** албан шаардлагын хугацаа болоогүй хэрэгжих шатандаа байна. Харин өмнөх оны 72.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага хэрэгжих шатандаа хугацаа болоогүй байна.



Зөвлөмжийн биелэлтийн талаар:

Тайлант хугацаанд **12,857.4** сая төгрөгийн зөрчилд үйл ажиллагааг сайжруулах, алдаа зөрчлийг засаж залруулах, хууль журмын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр **316** зөвлөмжийг хүргүүлснээс **9,269.9** сая төгрөгийн **264** зөвлөмжийн биелэлтийг, эхний хагас жилийн байдлаар биелэлт байгаа бөгөөд 3,587.5 сая төгрөгийн **52** зөвлөмж хэрэгжих шатандаа байна.



Санхүүгийн тайлангийн аудитын дүнг төсөв захирагчдаар танилцуулбал:

ОРОН НУТГИЙН ТЕЗ-ЧИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасан цаглаварт хугацаанд аймгийн ТЕЗ-ийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад илэрсэн алдаа зөрчлийг үнэлж, аймгийн ТЕЗ-ийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд



“Зөрчилгүй” санал дүгнэлтийг өгч, аудитын тайланг аймгийн ИТХ, засаг дарга болон ҮАГ-т хүргүүллээ. Аудитад 4 аудитор, хянан удирдах ажилтнууд оролцож, 14 өдөр зарцуулан 336 илүү цагаар суун ажиллаж аудитыг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэлээ. Мөн ҮАГ-т аймгийн ТЕЗ-ийн зөрчлийн нэгтгэл болон холбогдох 12 төрлийн судалгааг цаг хугацаанд нь хүргүүлэн ажилласан байна

ОНТЕЗ-ийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд сумдын ТТЗ-ийн 19, төсвийн шууд захирагчдын 156, төсөл сангийн 41, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 4 нийт 220 санхүүгийн тайланг нэгтгэсэн бөгөөд аймгийн засаг дарга дансны зардлын гүйлгээ хамрагдаж, нэгдсэн судалгаа хийн тулгалтыг хийсэн бөгөөд нийт орлого ба тусламжийн 78,428.7 сая төгрөгийн орлого, нийт цэвэр зарлага ба зээлийн 78,350.2 сая төгрөгийн гүйцэтгэлийг баталгаажууллаа.

Аудитын дүнд үндэслэн аймгийн засаг дарга, СТСХ болон ОНӨГ-ын дарга нарт 6 заалт бүхий зөвлөмж, 146.0 сая төгрөгийн 4 албан шаардлагыг хүргүүлэн ажилласан бөгөөд эхний хагас жилийн байдлаар албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх хугацаа болоогүй, хэрэгжих шатандаа байна.

Аудитын төгсгөлийн уулзалтыг 2021.04.27-нд аймгийн засаг дарга, ИТХ-ын дарга, аймгийн ЗДТГ-ын дарга, СТСХ-ийн дарга нартай хийж, аймгийн ТЕЗ-ийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг гардуулан өгч, аудитаар илэрсэн алдаа, зөрчил, цаашид анхаарах асуудлуудын талаар танилцууллаа. Үүнд:

1. ОНӨҮГ-уудын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитын дүнг танилцуулж, аймгийн ТЕЗ-ийн зүгээс ОНӨҮГ-уудад тавих хяналтыг сайжруулан мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах, үйл ажиллагаанд нь дүн шинжилгээ хийж, ашигт ажиллагааг дээшлүүлэх холбогдох арга хэмжээг авч ажиллах
2. Аймгийн тайланд тусгагдсан 854.6 сая төгрөгийн нэгдсэн халаалтад шилжсэнтэй холбоотой өр төлбөрийг барагдуулах талаар аймгийн ТЕЗ-ийн зүгээс холбогдох арга хэмжээг авч, цаашид өр төлбөр шинээр үүсгэхгүй байхад анхаарч сумдын удирдлагууд үүрэг чиглэл өгч ажиллах

Өмнөх аймгийн засаг даргатай холбоотой 30.9 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээг авах зэрэг асуудлуудын талаар ярилцаж, аймгийн засаг дарга, ИТХ-ын даргын зүгээс аудитын байгууллагатай хамтран ажиллахаа илэрхийлсэн нь аудитын үр өгөөж, үр нөлөөг нэмэгдүүлсэн уулзалт болсон

НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Орон нутгийн нийт орлого
ба тусламжийн орлого
78428.7 сая төгрөг

нийт зарлага ба цэвэр зээлийн
дүн **79350.2** сая төг

115.1 сая төгрөгийн
зөрчил илэрсэн

Төсвийн тухай хуулийн 8.9.4 дэх заалтын дагуу Төсвийн Ерөнхийлөн захирагчаас тайлагнасан Орон нутгийн ТЕЗ ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан нийт орлого ба тусламжийн **78428.7** сая төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн **79350.2** сая төгрөгийн гүйцэтгэлийг баталгаажууллаа.

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар засаг даргын хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг зориулалт бус, үр ашиггүй зарцуулсан **115.1** сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж, 4 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлэн ажиллалаа. Аудитаас өгсөн шийдвэрийн биелэлтийг тооцох хугацаа болоогүй хэрэгжих шатандаа байна.

СУМДЫН ТЕЗ-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасан цаглаварт хугацаанд 19 сумдын ТЕЗ-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, 18 сумын санхүүгийн тайланд “ зөрчилгүй, 1 сум буюу Хашаат сумын санхүүгийн тайланд “хязгаарлалттай” санал дүгнэлтийг хүргүүллээ. Аудитад ТАГ-ын 5 аудитор, хянан удирдах ажилтнууд, 1 гэрээт ажилтан оролцож нийт 19 өдөр зарцуулан, 397 цаг илүү ажилласан байна.

Төсвийн тухай хуулийн 8.9.2 дахь заалт, Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд 19-н сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд аудит хийж, 18 сумын тайланд “ Зөрчилгүй, Хашаат сумын тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлтийг хүргүүллээ.

Аудитаар нийт **4,133.8** сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, **161.0** сая төгрөгийн алдааг залруулж, **648.1** сая төгрөгийн зөрчилд 19 албан шаардлага, **3,324.7** сая төгрөгийн зөрчилд 35 заалт бүхий зөвлөмж хүргүүллээ. Мөн албан үүргээ биелүүлээгүй 4 албан тушаалтанд Төрийн аудитын тухай хуулийн 42.1 дэх заалтын дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэн биелэлтийг бүрэн хангууллаа.





Эхний хагас жилийн байдлаар **195.8** сая төгрөгийн **2** албан шаардлагын биелэлтийг хангуулсан **452.3** сая төгрөгийн **17** албан шаардлага, **3,324.7** сая төгрөгийн **35** заалт зөвлөмжийн хэрэгжих хугацаа болоогүй байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн энэ аудитаар сумдын төсвийн орлого нэр төрлөөрөө жигд ханган биелэгдээгүй, орлогын төлөвлөлтийг бодит тоон мэдээнд тулгуурлан төлөвлөх, Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажиллах, СХС-ийн хугацаа хэтэрсэн зээлүүдийг барагдуулах талаар дорвитой арга хэмжээ авч, эргэн төлөлтийг эрчимжүүлэн ажиллах албан шаардлага, зөвлөмжийг бүх сумдын удирдлагуудад хүргүүлсэн. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтийг хангуулснаар сумдын орон нутгийн орлого нэмэгдэх үр өгөөж бий болох юм.


ТУСГАЙ САНГИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аудитад Халамжийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Нийгмийн даатгалын 3 сангийн санхүүгийн тайлан хамрагдаж Зөрчилгүй санал дүгнэлт гаргалаа. Харин аймгийн Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сан, аймгийн эрсдэлээс хамгаалах сангийн 40 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгалаа. Аудитаар ХЭДСантай холбоотой 635.0 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг аудитын явцад арилгуулж, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлж ажиллах зэрэг 3 зөвлөмжийг хүргүүлж биелэлтийг хангуулан ажиллалаа.

ТБОНӨААН-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төсвийн тухай хуулийн 8.9.8 дахь заалт, Төрийн аудитын бүрэн эрхийн хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчит 6 хуулийн этгээдийн санхүүгийн тайланд аудит хийхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 5 хуулийн этгээдийн тайланд гэрээний үндсэн дээр хувийн аудитын компаниар гүйцэтгүүлж санал дүгнэлтийг үйлчлүүлэгчид хүргүүлж ажиллалаа. Харин Автотээврийн үндэсний төвийн Архангай аймаг дахь салбарын тайланг түүвэрт хамруулсан болно. Аудитад хувийн аудитын аудитын компанийн 4 ТАГ-ын 1 нийт 5 аудитор аудитад оролцон 61 өдөр зарцуулан 478 илүү цагаар ажилласан байна. Аудитаас хуулийн этгээдийн 1 тайланд “зөрчилгүй”, 3 тайланд “Хязгаарлалттай”, 1 тайланд санал дүгнэлт өгөхөөс татгалзлаа.

Аудитаар нийт 8,120.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 7,876.7 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэн, 85.7 сая төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага, 158.4 сая төгрөгийн зөрчилд 10 зөвлөмж хүргүүлснээс эхний хагас жилийн байдлаар албан шаардлага бүрэн хэрэгжсэн, 23.7 сая төгрөгийн 7 зөвлөмжийн биелэлтийг хангуулж, 134.7 сая төгрөгийн 3 зөвлөмжийг хэрэгжүүлэх хугацаа болоогүй хэрэгжих шатандаа байна.




ОНӨҮГ-уудын хувьд өөрийгөө санхүүжүүлэх хэмжээний үр ашигтай ажиллах үндсэн зарчмаа хангаж ажиллаагүй, үр ашиг, үр дүнгүй ажилласан нь аудитаас өөрчлөлттэй дүгнэлт гаргахад хүргэлээ. Иймээс ОНӨҮГ-уудыг өөрийгөө санхүүжүүлэх, үр ашигтай ажиллах талаар холбогдох арга хэмжээ авах шаардлагатай байгааг аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, ОНӨГ-ын дарга нарт танилцуулж холбогдох арга хэмжээ авахыг зөвлөлөө.

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цаглаварт хугацаанд улсын төсвийн 28, орон нутгийн төсвийн 197 нийт 225 төсвийн шууд захирагчдын тайлан аудитад хамрагдаж, 18 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлэн, 79 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан, 128 төсөв захирагчийн тайланд санал дүгнэлт гаргалаа. Үүнээс 117 төсөв захирагчийн тайланд “Зөрчилгүй”, 10 төсөв захирагчийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт тус тус гаргаж, харин 1 төсөв захирагчийн тайланд “Санал дүгнэлт өгөхөөс татгалзлаа.”

Аудитаар аудиторуудын өөрсдийн тодорхойлсон эрсдэл горим сорилын зэрэгцээ ковид, үндсэн хөрөнгө, цалингийн судалгаанууд, 2019-2020 онд санхүүгийн аудитад баримтлах чиглэлийн хүрээнд хийгдэх МУЕА ын тушаалын дагуу үйлчлүүлэгчдээс 8-н төрлийн асуудлаар судалгаа гаргуулан үнэлэх, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг нягтлан шалгах зэрэг ажлуудыг хийлээ.

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 21,732.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,533.4 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулан, 98.2 сая төгрөгийн 50 төлбөрийн акт тогтоож, 10,726.8 сая төгрөгийн зөрчилд 116 албан шаардлага, 9,374.2 сая төгрөгийн зөрчилд 265 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлэн ажиллалаа.



Эхний хагас жилийн байдлаар хүргүүлсэн шийдвэрийн хэрэгжилт 90.2% буюу 19,593.7 сая төгрөгийн зөрчил дутагдлыг барагдуулснаас 49.3 сая төгрөгийн 33 төлбөрийн актыг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, 10,687.0 сая төгрөгийн 113 албан шаардлага, 8,857.4 сая төгрөгийн 235 зөвлөмжийн биелэлтийг хангуулаад байна. Харин 48.4 сая төгрөгийн 21 төлбөрийн актын үлдэгдлийн 9.9 сая төгрөгийн 6 төлбөрийн акт нь ковидын нөхцөл байдлаас шалтгаалан хугацаа хэтэрч, 38.5 сая төгрөгийн 15 төлбөрийн актыг хэрэгжүүлэх хугацаа болоогүй байна. Мөн 39.8 сая төгрөгийн 3 албан шаардлага, 516.8 сая төгрөгийн 30 зөвлөмжийн хэрэгжих хугацаа болоогүй байна.



Аудитаас үндсэн хөрөнгийг холбогдох шийдвэргүй данснаас хасаж шилжүүлсэн, элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгө тайлан баланст бүртгэлтэй байгаа, төсвийн хөрөнгийг зориулалт бус үр ашиггүй зарцуулсан, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, шилэн дансны тухай, бусад хууль тогтоомж, заавар журмыг зөрчсөн зэрэг зөрчлүүдэд зөрчлийг арилгах, таслан зогсоох, хууль журмын хэрэгжилтийг ханган ажиллах албан шаардлага, зөвлөмжийг хүргүүлж, биелэлтийг хангуулан хөрөнгийн бүртгэл тооцоог хийлгүүлэн тайланд тусгуулж, өмч хөрөнгийг хадгалалт хамгаалалттай болгон, хөрөнгө эзэнгүйдэх, төсвийн хөрөнгийн зарцуулалтыг үр дүнгүй, үр ашиггүй зарцуулагдах эрсдэлээс сэргийлэн зөрчлийг таслан зогсоосноор санхүүгийн үр өгөөжийг бий болголоо.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

ТАГ 2021 оны эхний хагас жилд төлөвлөсөн 2 аудитыг бүрэн хийж, нэгдсэн удирдамжаар хийх “Хүнсний аюулгүй байдлыг хянах тогтолцоо, зарцуулсан хөрөнгийн үр дүн”-д хийх аудитын төлөвлөлтийн өмнөх шатны урьдчилсан судалгааны ажлуудыг гүйцэтгэж, холбогдох судалгаа, аудитын нэгдсэн төлөвлөгөө, арга зүйд тусгуулах саналаа АГГ-т хүргүүлээд байна. Гүйцэтгэлийн аудитад 5 хүн/давхардсан тоогоор/ нийт 59 өдөр зарцуулж 172 илүү цаг ажилласан байна. Тайлант хугацаанд гүйцэтгэсэн аудитад давхардсан тоогоор 10 байгууллага, тэдгээртэй холбогдох талуудын үйл ажиллагааг хамруулан шалгалаа.



Аудитаар нийт **20596.0** сая төгрөгийн зөрчил илрүүлж 1.1 сая төгрөгийг төсөвт буцаан төлөх акт тогтоон барагдуулж, зөрчил дутагдлыг арилгах, давтан гаргахгүй, таслан зогсоох 5935.6 сая төгрөгийн 18 албан шаардлага хүргүүлсэн нь хэрэгжих хугацаа болоогүй дараа улиралд биелэгдэхээр байна.



Аудитаар 14659.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх, төсвийн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн 22 зөвлөмжийг хүргүүлсэн ба хэрэгжих хугацаа болоогүй байна. Харин өмнөх онд нэгдсэн төлөвлөгөөний дагуу хийгдсэн Төрөөс ерөнхий боловсрол олгох үйл ажиллагаатай холбоотой аудитаас өгсөн 17 зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулаад байна.



Тайлангийн хугацаанд хууль хяналтын байгууллагад шинээр шилжүүлсэн асуудал байхгүй өмнөх онуудад шилжүүлсэн нийт 149.9 сая төгрөгийн 4-н асуудал хянагдаж байна.

Тайлангийн хугацаанд гүйцэтгэсэн аудитын үр дүнд нийт 20596.0 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг төлөвлөж бүртгээд байна.



НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ:

❖ УЛСЫН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ"-Т ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

2020 онд Архангай аймгийн Засаг даргад Төсвийн ерөнхийлөн захирагч нараас Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан 152,409.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, тухайн онд санхүүжих 47,013.0 сая төгрөгийн дүн бүхий 77 төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлсний 21 ТАХ нь он дамжих барилга угсралтын, 56 ТАХ нь тайлант онд ашиглалтад бүрэн орохоор эрх шилжин ирж төлөвлөгджээ. Ковид 19 цар тахлын дэгдэлтээс улмаас хөл хорио тогтоосон тул ТАХ-ний хэрэгжилтийг газар дээр нь үзэж шалгах зэрэг ажлууд хязгаарлагдаж, зарим албан тушаалтнууд тусгаарлалтад орсноос шаардлагатай зарим баримт материалыг хугацаа алдаж ирүүлсэн зэрэг хүндрэл бэрхшээл тулгарч ирүүлсэн баримт материалын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитын дүнгээс гэрээний хугацаа хэтрүүлсэн, ТАХ-г дутуу, чанаргүй хийсэн **42.0** сая төгрөгийн зөрчлийг гүйцэтгэгч нараар арилгуулах, **4859.0** сая төгрөгийн ТАХ-ний гүйцэтгэгчээр шаардлага хангахгүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан зөрчлийг таслан зогсоож тэдгээрийн гэрээ хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах нөхцөлийг бий болгох, 126.5 сая төгрөгийн хяналтын зардлыг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байхад чиглэсэн үр ашигтай арга хэмжээ авах 4 албан шаардлагыг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлээд байна.

Аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй, 14494.3 сая төгрөгийн үнэ бүхий 6 үндсэн хөрөнгийн эзэмшигч, ашиглагчийг тодорхой болгож тэдгээрийн бүртгэлд тайланд тусгуулан төсвийн санхүүжилтээр бий болсон хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх үр дүнтэй арга хэмжээ авах 9 заалт бүхий зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлээд байна.

Албан шаардлага зөвлөмжийн биелэлтийг тооцох хугацаа болоогүй бөгөөд дараагийн улиралд биелэлтийг хангуулж аудитын шийдвэрийн үр нөлөөг үнэлэх үр өгөөжийн хүлээн зөвшөөрүүлэх арга хэмжээг авахаар төлөвлөөд байна. Аудитаас орон нутагт эрх шилжүүлсэн ТАХ-ний санхүүжилтэд хяналт тавих эрхийг хамт шилжүүлэх саналыг ТЕЗ нарт хүргүүлэхээр ҮАГ-т уламжилж ажилласан.

Аудитаас өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг хангуулснаар УТХО-ын ТАХ-г оновчтой төлөвлөж, олон нийтийн хүлээж буй хөрөнгө оруулалтын хэрэгцээг шаардлагыг ханган, хүртэх үр ашиг, үр нөлөөг нэмэгдүүлэх үр өгөөж бий болохоор байна.



ӨӨРИЙН САНААЧИЛГААР ХИЙСЭН АУДИТ

❖ “ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2020 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР АШИГ, ҮР НӨЛӨӨ” -АУДИТ

Аудитад 2 хүн 21 өдөр зарцуулж, 5-н байгууллагыг хамруулан 48 цаг илүү ажилласан байна. Аудитад орон нутгийн авто замын сан, хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 1,229.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 ТАХ-ний төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, үр дүнд чиглэн 3 байгууллагыг хамруулан шалгалаа.

Аудитаас аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн зарим төсөл арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, зорилтод түвшинг хангаагүй нь төлөвлөлтийг бодлогын баримт бичигтэй уялдуулаагүй, хэрэгцээ шаардлагыг тооцоогүй, зураг төсвийг хийдэггүй холбоотой байна гэж дүгнэлээ.

Аудитаар нийт **397.1 сая төгрөгийн** зөрчил илрүүлсэнд 396.0 төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх таслан зогсооход чиглэсэн 2 албан шаардлагыг холбогдох байгууллагуудад, 1.1 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсныг төсөвт буцаан төлүүлэх 1 төлбөрийн акт тогтоон, хөрөнгө оруулалтын ТАХ-ний хэрэгжилт, үр дүн, үр ашгийг сайжруулахад чиглэсэн 3 зөвлөмжийг аймгийн Засаг дарга болон холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэн ажиллаа.

Аудитаас өгсөн албан шаардлага зөвлөмжийн мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлснээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг эдийн засгийн тооцоо, судалгаа, зураг төсөвт үндэслэн нэн шаардлагатай хөрөнгө оруулалтыг төлөвлөх, санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгох, бий болсон хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зэргээр орон нутгийн хөрөнгө оруулалтын олон нийтийн хүртэх үр өгөөж нэмэгдэх үр дүнг бий болох юм.

Төрийн аудитын байгууллагын 2021 онд нэгдсэн төлөвлөгөөний дагуу аймгийн ИТХ-ын саналаар “Орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны хөрөнгийн зарцуулалт” -д аудитыг хийж 2 хүн оролцож, гүйцэтгэлээ. ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэх “Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт”-д хийх аудитын хүрээнд урьдчилсан судалгааны ажлыг гүйцэтгэж, орон нутаг дахь нөхцөл байдал, эрсдэлийн үнэлгээ, хамрах хүрээ, аудитаар авч үзэх асуудлын талаар Санхүүгийн хяналт дотоод аудитын хэлтэс, ЗДТГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн тайлангуудад үндэслэн санал бэлтгэн 2021.05.28-ны өдөр ҮАГ-ийн Гуравдугаар газарт хүргүүлээд байна.



➤ **ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН АУДИТ**

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны хөрөнгийн зарцуулалт”-д хийсэн нийцлийн аудитын нээлтийг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ, ГХБХБГ, аймгийн ОНӨГ-ын холбогдох мэргэжилтнүүдийн хүрээнд хийж “zoom” программ ашиглан аймгийн бүх сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга, Санхүү албаны дарга, нягтлан бодогч нарын 68-н албан албан тушаалтанд онлайнаар холбогдож **аудитын нээлтийг хийж** төлөвлөгөө, хөтөлбөр, шаардлагатай судалгаа, мэдээлэл, санал асуулгыг танилцуулж, аудитын явцад анхаарах асуудлын талаар ярилцаж, харилцан санал солилцож ажиллалаа.

Энэ нь хүний нөөцийн хүрэлцээгүй, ажлын ачаалал их байгаа үед цаг хугацаа, төсөв хөрөнгө хэмнэсэн үр дүнтэй ажил боллоо.

Аудитад нийцлийн аудит хариуцсан 2 аудитор, хянан удирдах ажилтнууд оролцож хөтөлбөрийн дагуу 65 хүн өдөр гүйцэтгэж дуусгасан байна. Аудит хийж байгаа цаг хугацаанд Ковидтой холбоотой хөл хорио тогтоосон аймгийн Засаг даргын захирамж гарч 2021 оны 4 сарын 15-наас 25-ныг дуусталх хугацаанд тэг зогсолт хийсэн тул аудитын гүйцэтгэлийн үе шатанд хийгдэх зарим ажлууд хязгаарлагдаж, баримтад тулгуурлан хийж гүйцэтгэсэн.

Аудитаар нийт 3,919.8 сая төгрөгийн зөрчил илэрсэнд аудитаас 3,592.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмжийг аймаг, сумдын Засаг дарга нарт, 326.9 сая төгрөгийн нэг албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна. Аудитын тайлангаар аймгийн ИТХ-д 2 заалт, аймгийн Засаг даргад 2,956.9 сая төгрөгийн 4 заалт, Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-д 1 заалт зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.

Харин 17 сумын Засаг дарга нарт 636.0 сая төгрөгийн зөвлөмжийг хураангуй тайлангаар хүргүүлээд байна. Нийцлийн аудитын тайлан, аудитын дүнг аймгийн ЗДТГ-ын дарга, СТСХ-ийн дарга, ГХБХБГ-ын дарга, ОНӨГ-ын дарга нар болон байгууллагын удирдлагын зөвлөлийн гишүүдэд өргөтгөсөн хэлбэрээр танилцуулж, цаашид анхаарах асуудлуудын талаар харилцан санал солилцож, төгсгөлийн уулзалтыг зохион байгууллаа. Мөн сумдын удирдлагуудад онлайнаар аудитын тайланг танилцуулж ажиллалаа. Аудитаас өгсөн шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг 2021.10.01-ний өдрийн дотор ирүүлэхээр байна.

ТАВДУГААР БҮЛЭГ. ДОТООД АЖЛЫН ТАЛААР

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ :

- ❖ Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас Төсвийн тухай хууль болон Төрийн аудитын тухай хуулийн 6.3.2 " аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, аймаг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх" гэсэн заалтын дагуу орон нутгийн 2022 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, зардал



бууруулах, үр ашиг дээшлүүлэх талаар санал, дүгнэлт өгөх, аймгийн ИТХ-д хүргүүлэх” ажлын төлөвлөгөөг 2021.05.25-ны өдөр Тэргүүлэх аудиторoor батлуулан ажиллаж байна. Өмнөх жилүүдэд орон нутгийн төсвийн орлого нэмэгдүүлэх зардал бууруулах, үр ашгийг дээшлүүлэх саналыг хуульд заасан 10 хоногийн хугацаанд хэрэгжүүлэн саналыг хүргүүлэн ажилладаг байсан. 2022 оны төсвийн төсөлд хүргүүлэх саналыг бодит тооцоо судалгаанд үндэслэгдсэн, хэрэгжихүйц байхад голлон анхаарч аймгийн 19 сумын орон нутгийн орлогын төсвийн төсөл, төлөвлөгөө, гүйцэтгэлд сүүлийн 3 жилээр судалгаа дүн шинжилгээ хийж холбогдох мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдийн тооцоолол, төсөөлөл зэрэгт судалгаа, дүн шинжилгээний ажлыг хийж байна.

ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ХҮРЭЭНД :

- ❖ МУЕА-ын орлогч болон МТТөвөөс 2021 оны 04 сарын 13-нд зохион байгуулсан Шилэн дансны цахим системийн талаарх сургалт, 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан "ТАБ-ЫН ШИНЭЭР БАТЛАГДСАН ДҮРЭМ, ЖУРМУУДЫГ ТАНИЛЦУУЛАХ ЦУВРАЛ СУРГАЛТ-И" цахим сургалтад бүх аудиторууд бүрэн хамрагдлаа. Харин МТТөвөөс 2021 оны 05 сарын 28-нд зохион байгуулсан "Статистикийн мэдээг бүртгэх" цахим системийн сургалтад Тэргүүлэх аудитор, аудитын менежер, мэдээ хариуцсан аудиторууд хамрагдсан. ҮАГ-аас зохион байгуулсан сургалтад нийт аудиторууд бүгд идэвхтэй хамрагдсан бөгөөд сургалтаар өгсөн мэдлэг, мэдээллийг үйл ажиллагаандаа амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал: Шилэн дансны цахим мэдээллийн сан, Статистик мэдээний цахим мэдээллийн санг хөтлөх талаарх сургалтын дагуу бүх мэдээллийг ҮАГ-аас заасан хугацаанд цахим систем шивж оруулж дууссан, одоо үйл ажиллагаандаа цахим системийг ашиглаж байна.
- ❖ ММНБИ-ээс гишүүддээ зориулан 2021 оны 05 сарын 15-ны өдрөөс эхлүүлсэн тасралтгүй боловсролын 21 кредит цагийн багц цахим сургалтад манай байгууллагын МНБ нар болох Тэргүүлэх аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Байгалмаа, ахлах аудитор Д.Нэргүйбаатар, Н.Алтантуяа, аудитор П.Энхжаргал, нягтлан бодогч архив бичиг хэргийн ажилтан Л.Соёлмөнх нар хамрагдаж байна.
- ❖ ТАГ-ын ажилтнуудыг ажлын байранд тасралтгүй сургах, чадавхжуулах үүднээс мэргэжлийн тасралтгүй сургалтын сэдвийн саналыг бүх ажилтнуудаас онлайнаар авч нэгтгэн гаргаж "Мэргэжлийн тасралтгүй сургалтын төлөвлөгөө"-г Тэргүүлэх аудиторын 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/14 тоот тушаалаар батлан төлөвлөгөөний дагуу 2021 оны 6 дугаар сарын 15-ны байдлаар 7 удаагийн сургалтыг зохион байгуулахаас 6 сургалтыг зохион байгуулсан байна. Сургалтад нийт ажилтнууд 90-100



хувийн ирцтэй хамрагдаж зохих мэдлэг арга зүйд суралцан ажиллаж байна. Дараах сэдвийн хүрээнд сургалтыг зохион байгуулаад байна. Үүнд:

1. "ТАБ-ын албан хаагчийн Ёс зүйн дүрэм" -2021.05.11
 2. "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-2021.05.13
 3. Гүйцэтгэлийн аудитын чанарын баталгаажуулалтын зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн ажил-2021.05.21
 4. Санхүүгийн тайлангийн аудитын чанарын баталгаажуулалтын зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн ажил-2021.05.21
 5. Нийцлийн аудитын чанарын баталгаажуулалтын зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн ажил-2021.06.03
 6. Аудитын түүвэрлэлт хийхэд ашигладаг зарим программын талаар-2021.06.11
- Ажилтнууд өөрсдөдөө нэн тэргүүнд шаардлагатай сэдвүүдийн захиалгыг өгч өөрсдөө хичээлээ зааж харилцан ярилцан, сайн туршлага хуваалцах зэрэг арга хэлбэрээр хичээлийг сонирхолтой байдлаар зохион байгуулж байна. Сургалтын төлөвлөгөөгөөр хичээл 2021 оны 12-р сар хүртэл үргэлжлэхээр байгаа бөгөөд ажилтнуудад аймгийн Төрийн албаны салбар зөвлөл, аймгийн Прокурор, Санхүү Төрийн сангаас төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Төсөв санхүүгийн талаар орон нутгийн баримтлах бодлого чиглэлээр хичээл заалгахаар холбогдох байгууллагатай харилцан ярилцаж, тохиролцоод байна.

- ❖ ТАБ ын дотоод журмын 6.1.6 дэх заалтын дагуу шинэ хүүхэдтэй болсон аудитор Г. Цог-Эрдэнэд хагас сарын цалин 0.7 сая төгрөг, Дотоодын их дээд сургуулийн магистрантад суралцаж байгаа аудитор Х. Алтанчимэгт журмын дагуу сургалтын төлбөрийн 30% тай тэнцэх хэмжээний тусламж олгуулах олгохоор хүсэлтийг Тамгын газарт уламжлан, шийдвэрлүүлээд байна.
- ❖ Ковид цар тахалтай холбогдуулан ажилчдыг халдвар хамгаалал, дархлаажуулалт, вакцинжуулалтын 1, 2-р тунд хамруулан, ажлын өрөөнүүдийг бүрэн ариутгалд хамруулан_ халдвар хамгаалалтын хэрэгсэл авч өглөө.

❖

ДОТООД АЖЛЫН ТАЛААР :

2021 онд байгууллагын дотоод үйл ажиллагааны хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ❖ Байгууллагын бүх ажилтнуудаар ХАСХОМ ийг хуульд заасан хугацаанд гаргууллаа.
- ❖ ТАГ-ын ажилтнууд ёс зүйн хэм хэмжээг сахих, ашиг сонирхлын зөрчилд орохгүй байх, гэмт хэрэг зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх үүднээс аудит бүрийн эхэнд ажилтнуудаас ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг гаргуулан авч баримтжуулж байна.



- ❖ Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хууль тогтоомж зааварт нийцүүлэн гүйцэтгэх, ирсэн явсан албан бичгийг бүртгэж, тухай бүрд нь цохогдсон албан тушаалтанд танилцуулан шийдвэрлэлтэд цахим бүртгэлээр хяналт тавьж, программ ашиглан цахим сан үүсгэн ажиллаж байна.
- ❖ 2021 оны эхний хагас жилийн байдлаар Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирсэн албан бичиг 353, ҮАГ-аас 40, бусад байгууллагаас 596 ирсэн, үүнээс хариутай бичиг 37, шийдвэрлэсэн нь 37 байна. Ирсэн, явсан бичиг, акт, албан шаардлага, зөвлөмж, гэрчилгээнүүдийг тухай бүр цахим файлын санг үүсгэн архивлаж, баримт бичгүүдийг цахим хэлбэрт оруулан ажиллаж байна. Хамт олны хурал 1 удаа хуралдлаа. 2021 онд байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой нийт 26 тушаал шийдвэр гарсан байна.
- ❖ Байгууллагын ББНШК-ын энэ 2021 оны анхны хурлыг хийж, 2021 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гарган, Тэргүүлэх аудиторовын 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлуулан мөрдөж ажиллаж байна.
- ❖ Байгууллагын санхүүгийн 2020 оны санхүүгийн тайланд “Мишээл од-Аудит” ХХКомпаниар аудит хийлгэж “Зөрчилгүй” санал дүгнэлтийг авлаа.
- ❖ 2020 онд Чанарын баталгаажуулалтын албанаас хийсэн санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитыг шалгаж, зөвлөмж ирүүлсний дагуу зөвлөмжийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг Тэргүүлэх аудиторар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ төлөвлөгөөний дагуу аудитын төрлөөр хариуцсан ахлах аудиторуд төлөвлөгөөний хэрэгжилт цаашид анхаарах асуудлын талаар илтгэл тавилаа.
- ❖ Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Д.Уламбаяр тэтгэвэр тогтоолгох насанд хүрч, төрийн албанаас чөлөөлөгдсөн тул МУЕА ын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн Б/220 дугаар тушаалын дагуу 39.4 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг байгууллагын төсвөөс олголоо.
- ❖ Байгууллагын дотоод ажлын төлөвлөгөөний дагуу “Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”, “Эх үрсийн баярын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай дотоод журмын 6.6.1, 6.6.2 -д заасны дагуу эмэгтэй ажилтнууд болон ажилтнуудын хүүхдүүдэд 1.3 сая төгрөгийн гарын бэлэг хүргүүлээ.
- ❖ ТАГ т ҮАГ ын Тамгын дарга ажиллаж, улмаар аймгийн Засаг даргад Төрийн аудитын газрын ажилтнуудын нийгмийн тодорхой асуудлыг шийдвэрлэх санал тавьсны дүнд 5-н ажилтанд гэр бүлийн хэрэгцээний газар олгуулах болон төрийн албан хаагчдын орон сууцанд хамруулах, Тэргүүлэх аудиторовын өрөөнд засвар хийх болон, зөөврийн компьютер тоног төхөөрөмж асуудлыг шийдэхээр тохиролцоод байна. Энэ дагуу аймгийн Засаг даргад албан хүсэлтийг хүргүүлсэн бөгөөд эхний ээлжид зөөврийн компьютер, болон өрөө байрны засварын асуудлыг орон нутгийн төсвийн тодотголоор шийдэж өгөх урьдчилсан хэлэлцээг СТСХ тэй хийгээд байна.



ТАВДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2021 оны эхний хагас жилд 293861.7 мянган төгрөгийн санхүүжилт ирсний 83.9% буюу 246637.9 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан. Үүнд: Цалин хөлс болон нэмэгдэлд 176383.6 мянган төгрөг, НДШ-д 24076.1 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 3863.7 мянган төгрөг, томилолт, зочны зардалд 540.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1800.0 мянган төгрөг, нэг удаагийн буцалтгүй тэтгэмж 39974.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. Эхний хагас жилд хангамж бараа материалын батлагдсан зардал 2117.4 мянган төгрөгөөр дутуу санхүүжигдсэнээс бичиг хэргийн зардал 641.6 мянган төгрөг, шуудан холбооны зардал 155.8 мянган төгрөг, шатахууны зардал 1320.0 мянган төгрөгийн өр үүсэхээр байна.

Байгууллагын төсөвтэй холбоотой сарын мэдээг тухай бүр Санхүү төсөв, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлж ажиллалаа. Нэмэлт санхүүжилтийн дансаар 19.4 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлсөнд 10.8 сая төгрөгийг Монголиан бизнес рейтинг -аудит ХХК -д шилжүүлээд байна.

Архангай аймаг дахь Төрийн аудитын газар 2022 оны үйл ажиллагааны төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг хуульд заасан хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж нэгтгүүллээ.

2021 оны эхний хагас жилийн байдлаар Шилэн дансны тухай хуулийн дагуу цахим сайтад байршуулбал зохих нийт 75 мэдээллийг 100 хувь бүрэн хугацаанд нь байршууллаа.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. САНАЛ ДҮГНЭЛТ

Архангай аймаг дахь Төрийн аудитын газар Үндэсний аудитын газраас дэвшүүлсэн **“Аудитыг цахимжуулж, нэгтгэн удирдах тогтолцоог бүрдүүлэн, төлөвшүүлэх”** зорилтын хүрээнд 2021 оныхоо гүйцэтгэлийн төлөвлөгөөг хугацаанд нь чанартай хэрэгжүүлэхээр үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР